MMINFO.

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Хүн ам 3,117.076... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.11.22. Мягмар. №209 (4579) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

ЯРИЛЦАХ ТАНХИМ

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧ ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН ТӨВТЭЙ ТАНИЛЦАВ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

АХМАДУУДАА ХООСОН ҮЛДЭЭСЭНГҮЙ, ГЭХДЭЭ...

V нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## М.Лхачинбал:

### “МАХ ИМПЭКС” БОЛ МОНГОЛ УЛСАД МАХНЫ АЖ ҮЙЛДВЭР ҮҮСЧ ХӨГЖИХ ЭХЛЭЛИЙГ ТАВЬСАН АНХНЫ ГАРААНЫ ҮЙЛДВЭР

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

ҮЗЭЛ БОДОЛ

## МОНГОЛЫН ТӨР

### ДАХИАД Л ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГОО ХӨСӨР ХАЯЛАА

Н.ПУНЦАГБОЛД

Улсын хүн хамгийн багадаа дөрвөн саяд хүрч байж хөгжлийн дугуй нь хурдан эргэж эхэлдэг талаархи эрдэмтдийн судалгаа байдаг юм билээ. Гэтэл манайх одоогоор 3.1 сая хүнтэй л байна. 20 гаруй жилийн турш хоёрхон саяулаа гэгдэж байсныг бодвол бас ч гэж өсчихлөө. Гэхдээ л энэ их өргөн уудам нутагт хүн нь үнэхээр цөөдөх юм аа. Манайхан “Монголчууд таван сая хүрвэл дэлхийг эзэлнэ гэж бусад улсууд айдаг юм гэнэ билээ” гэж өөрсдийгөө хөөргөдөг. Дэлхийг эзлэх нь ч юу юм. Гэхдээ л хүн ам нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн эргэлт хурдасч, улс орны хөгжил тэлнэ. Гэвч Монголын төр засгаас хүн амын өсөлт рүү чиглэсэн дорвитой бодлого бараг байсангүй. Ингээд бичихээр худлаа гүжирдлээ гэх эрх мэдэлтэн, элдэв сэтэртэн гарч ирэх байх. Тийм ээ, бодлого гаргаагүй биш гаргасан. 2004 онд гэхэд “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” гээчийг гаргаж байж. Тэр баримт бичигтээ төрөлтийг дэмжих, өөрөөр хэлбэл хүн амын өсөлтийг дэмжсэн зүйл, заалтуудыг оруулж өгч байж. Тухайлбал, төрөхийн өмнөх, төрсний дараахь болон хүүхдээ өсгөхөд шаардлагатай эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Д.Трамп шиг зангарагтай бай л даа

Б.ДАВАА

Дэлхийн хүчирхэг нэгэн гүрнийг ирэх дөрвөн жилийн турш тэргүүлэх эрхмийг сонгох сонгууль энэ сарын 8-нд явагдаж, “нялх” улстөрч Доналд Трамп ялалт байгуулсан билээ. Улс төрийн салбарт асар их туршлагатай Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтоныг давж, 45 дахь Ерөнхийлөгчөөр тодорсон тэрбээр тангараг өргөснөөсөө хойш бүрэн эрхийнх нь хугацаа дуусах хүртэл цалин авахгүй. АНУ-ын төрийн тэргүүн жилдээ 400 мянган ам.долларын цалин авах бөгөөд “Трамп” гэх нэрээ үл хөдлөх хөрөнгийн бизнест тамгалчихсан эл эрхэмд энэ мөнгө хэрэггүй гэдгээ ялалт байгуулахаасаа өмнө ч, дараа нь ч илэрхийлсэн удаатай. Угтаа 3.7 тэрбум ам.долларын хөрөнгөтэй эрхэмд жилийн 400 мянган ам.долларын Ерөнхийлөгчийн цалин магадгүй хоолны мөнгөнөөс нь хэтрэхгүй биз.

Үргэлжлэл нь III нүүрт






Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.

Free Bag + 2 Years + McAfee SECURE

PC mall

7575-3535

Алдаж болохгүй алтан боломж

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2422.00 | 2442.00 | ФУНТ | 2939.00 | 3054.00 |
| ЕВРО | 2534.00 | 2614.00 | РУБЛЬ | 36.00 | 39.10 |
| ИЕН | 21.961 | 22.23 | ЮАНЬ | 350.30 | 357.50 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2420.00 | 2446.00 | ФУНТ | 2960.00 | 3072.00 |
| ЕВРО | 2539.00 | 2637.00 | РУБЛЬ | 36.34 | 39.89 |
| ИЕН | 21.60 | 22.45 | ЮАНЬ | 349.00 | 358.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ЕРӨНХИЙЛӨГЧ ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН ТӨВТЭЙ ТАНИЛЦАВ





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.БАТЗАЯА

Нийслэлийн хүн амд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшиг, осол гарсан тохиолдолд хийх алхамуудын талаар мэдлэг, дадлага олгох сургалтуудыг зохион байгуулж байх Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв өнгөрсөн зургадугаар сард ашиглалтад орсон билээ. Тэгвэл тус төвийн үйл ажиллагаатай өчигдөр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танилцсан юм. Энэ үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Өнгөрсөн жилүүдэд ҮАБЗ-ийн хүрээнд бид гамшгийн асуудлыг нэлээд авч ярилцсан. Санаа зовоож байгаа нэг гамшиг бол газар хөдлөлтийн гамшиг юм. Мянгаад жилийн өмнө, Улаанбаатарын энэ бүсэд газар хөдөлж байсан гэдэг дүгнэлт байдаг. Тэр мянгаад жил нь одоо болчихсон. Дээр нь Улаанбаатарыг тойрсон газар хөдлөлтийн маш хүчтэй хагарлууд бий. Хагарлууд хоорондоо уулзах иймүйл явц ойрхон болж байгаа. Нэг үгээр хэлбэл, ойрын маш богинохон хугацаанд Улаанбаатар хотод маш хүчтэй газар хөдлөлт болох хандлага байна гэдгийг гадаад, дотоодын судлаачид, эрдэмтэд гаргаж ирж, үргэлж анхааруулж байгаа. Энэ талаар УИХ-д мэдээлэл хийсэн. Жил бүрийн нэгдүгээр сард бүх байгууллагуудаас мэдээлэл авдаг. Энд хэлэх гэсэн хамгийн гол хоёр зүйл байна. Аливаа төрийн хамгийн гол үүрэг бол иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах, мэдээлэл өгөхөд оршдог. Тийм учраас Улаанбаатараас эхлээд иймтөвүүдийг байгуулъя. Цаашдаа Дархан, Эрдэнэт, аймгийн төвүүдэд иймтөвүүдийг байгуулъя. Хамгийн гол нь байгалийн гамшгийг тойрч гарах ямар ч боломжгүй. Үүнийг зогсоох боломжгүй. Газар хөдлөлийг зогсоосон орон хаана ч байхгүй. Яавал бага хохиролтой гарах вэ. Бэлтгэлтэй л байвал бага хохиролтой гардаг. Хүмүүс нь мэдээлэлтэй байвал бага хохиролтой гардаг. Япон улсад гэхэд газар хөдлөлт болоход бие биеэ аварсан хэмжээ нь гэвэл хажуу хөршөө аварсан нь 80 хувьд хүрч байсан. Нэг үгээр хэлбэл, хүн өөрөө амьд гараад, хажуудах хүмүүсээ аварч чадах юм бол 80 хувийг аварч чаддаг. Хамгаалагч, төр, бусад газрыг хүлээх ямар ч боломжгүй үед иймбайгаа. Иймнөхцөлд бид бэлтгэлтэй байх ёстой гэсэн үүднээс сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдээс эхлээд албан байгууллагуудад бүгдэд нь газар хөдлөлтийн тухай, гамшгийн тухай мэдээллийг тарааж, хүргэж байгаа. Иргэд, хүүхдүүд, сургууль цэцэрлэгийнхэн энд ирээд нэг удаа сургалт хийгээд гарахад амьдралынхаа турш өөрийгөө аваад явах мэдлэгтэй болох юм шүү гэдгийг хэлье” гэв. Түүнийг Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн хурандаа Н.Уламбаяр болон ОБЕГ-ын дарга, бригадын генерал Т.Бадрал угтан авсан бөгөөд Газар хөдлөлтийн танхим, Өндрөөс аврах ажиллагаа үзүүлэх танхим, Утаат орчны дадлага хийх танхим, Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сургалтын танхим, 150 хүний багтаамжтай орчин үеийн тоноглол бүхий үзвэрийн 3D бичил кинотеатр зэрэгтэй танилцсан юм. Тус төвд болзошгүй гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг хэрхэн аврах талын мэдлэг, дадлыг иргэд, олон нийт, хүүхэд багачуудад олгож, сургалт, дадлагад хамруулдаг байна. Тухайлбал, газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн объектыг орхиж аюулгүй орчинд хүрэх, өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж яаж үзүүлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглаж сурах зэрэг иргэдийн нэн түрүүнд мэдэх шаардлагатай мэдлэг, дадлыг тус сургалтын төвд олгох ажээ. Мөн газар хөдлөлтийн танхимд 6-8 баллын чичирхийллийг биеэр мэдрэх боломжтой бөгөөд БНХАУ-ын Сычуань мужийн жишгээр тоноглож, техник хэрэгсэл суурилуулсан гэдгийг албаныхан онцолсон. Ерөнхийлөгчийг тус төвд айлчлах үеэр “Элит” олон улсын сургуулийн сурагчид хичээлийнхээ дадлагыг хийж таарсан юм. Тус сургуулийн хичээлийн агуулгад байгалийн гамшгийн эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар орсон байдаг байна. Энэхүү төвтэй танилцсанаар хичээл илүү сонирхолтой, ойлгомжтой болж байгаа талаар “Элит” сургуулийн сурагчид хэлж байлаа.

...Газар хөдлөлтийн танхимд 6-8 баллын чичирхийллийг биеэр мэдрэх боломжтой бөгөөд БНХАУ-ын Сычуань мужийн жишгээр тоноглож, техник хэрэгсэл суурилуулсан гэдгийг албаныхан онцолсон. Ерөнхийлөгчийг тус төвд айлчлах үеэр “Элит” олон улсын сургуулийн сурагчид хичээлийнхээ дадлагыг хийж таарсан юм...

ШАР МЭДЭЭ

## АН-ынхан арчаагаа алдав уу

Э.МӨНХ



Уг нь хуваарийн дагуу бол өчигдөр УИХ дахь намын бүлгүүд хуралдах ёстой байсан. Гэвч УИХ дахь Ардчилсан намын бүлэг хурлаа цуцалсан юм. Өнгөрсөн долоо хоногт ч ҮЗХ хуралдана гэсэн шалтгаанаар бүлгийн хурал цуцлагдсан. Өмнө нь олонхи байхдаа цаг наргүй хуралдаж байсан тэд өнөөдөр халаагаа өгсөн болохоор хуралдах эсэх нь хамаагүй болсон бололтой. Угтаа бол МАН-ынханд хяналт тавьж, сөрөг хүчний үүргээ гүйцэтгэх ёстой ч 65 кнопны эсрэг хөдөлж чадахгүй болохоороо арчаагаа алдаж, хурлаа ч хийж чадахгүйд хүрэв үү. Ямартай ч, өмнөх шалтгаан нь ҮЗХ байсан бол өчигдрийн шалтгаан нь хоёр гишүүн нь гадаадад ажиллаж, бусад гишүүд нь орон нутгийн төлөөлөгчдөө хүлээн авч уулзах зэрэг ажилтай байгаатай холбоотой гэнэ шүү.

МЭДЭЭЛЭЛ

## Хөгжлийн банкны шалгалтын дүнг хэлэлцэв

УИХ дахь МАН-ын бүлгийн хурлыг 14.00 цагт товлосон ч ирц бүрдэхгүй байсаар товлосон цагаасаа нэлээд хоцорч эхсэн. Бүлгийн хуралд 30 орчим гишүүн оролцсон юм. Өчигдрийн хурлаар Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, эдийн засгийн хямралыг даван туулах тогтворжуулах хөтөлбөрийг хэлэлцэн, байр сууриа нэгтгэжээ. Энэ удаагийн бүлгийн хуралдаан сунжирч дугаар шилжих мөчид Төрийн ордны “Б” танхимд үргэлжилж байлаа. Хурлаар Хөгжлийн банкинд хийсэн ажлын хэсгийн шалгалтын дүнг сонсч буй аж. Засгийн газар байгуулагдсаныхаа дараахан Хөгжлийн банкны үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяраар ахлуулан байгуулсан байдаг. Тус ажлын хэсэг шалгалтын дүнгээ өнгөрсөн аравдугаар сард олон нийтэд ил болгосон бөгөөд Хөгжлийн банкнаас 1.3 их наяд төгрөгийн зөрчил илэрсэн хэмээн мэдэгдсэн юм. Авлигатай тэмцэх газраас Хөгжлийн банкны захирал асан Н.Мөнхбатыг саатуулсан. Энэ үйл явцыг улс төрийн хүрээнийхэн “Засгийн газраас гаргасан шийдвэрийг үндэслэн Хөгжлийн банкны захирал зарцуулалт хийх үүрэгтэй болохоос биш дангаараа шийдвэр гаргах эрхгүй. Иймээс дан ганц энэ асуудалд Н.Мөнхбатыг буруутгах нь зохисгүй” гэх байр суурийг ч олонтаа илэрхийлж байгаа юм.

МЭДЭЭЛЭЛ

## Шинэ үеийн залуус стратегийн түншлэлийг сонгож байна

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, Н.Цэрэнбат, Н.Учрал нар ОХУ-ын Төрийн думын дэд дарга Сергей Железняк болон ОХУ-Европын парламентын бүлгийн дарга, Андрей Климов нартай уулзаж хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна. Бүс нутгийн хөгжил болон тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн Засгийн газар хоорондын хамтын ажиллагаагаар хязгаарлагдахгүй төрийн бус байгууллагууд, тэр дундаа тухайн бүс нутгийн залуучуудын оролцоо чухал юм. Энэ хүрээнд Нэгдсэн Орос намаас зохион байгуулсан Евро-Азийн бүс нутгийн хөгжлийн асуудлаар олон улсын форум, хэлэлцүүлэгт оролцохын зэрэгцээ УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн “Нийгмийн Ардчилал” Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгчийн хувиар Нэгдсэн Орос намын дэргэдэх “Молодая Гвардия” Бүх Оросын залуучуудын байгууллагатай стратегийн түншлэлийг хэрэгжүүлэх Хамтын Ажиллагааны Хэлэлцээр байгуулжээ. УИХ-ын гишүүн, НАМЗХ-ны ерөнхийлөгч Г.Тэмүүлэнгийн хэлсэнээр Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд тогтоосон уламжлалт ах дүүгийн харилцааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс хэлэлцээрийн дагуу залуучуудын солилцооны хөтөлбөрийг хөгжүүлэх, дунд, урт хугацааны сургалт хэрэгжүүлэх, хил залгаа бүс нутгийн хөгжлийг дэмжих, соёл, улс төр, бизнес, шинжлэх ухаан, байгаль экологийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Мөн энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол, Оросын залуу бизнес эрхлэгчдийн уулзалтыг Улаанбаатар, Москва, Эрхүү хотуудад жил бүр зохион байгуулахаар тохиролцсон ажээ.

## Их хуралд бэлтгэх дэд ажлын хэсэг байгууллаа

АН-ын Үндэсний зөвлөлдөх хороо өнгөрсөн долоо хоногт хуралдаж, намын дүрмийн шинэчлэлийг боловсруулах, Их хуралд бэлтгэх ажлын хэсэг байгуулсан. Ардчилсан намын их хуралд бэлтгэх ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатаар ахлуулж, бүрэлдэхүүнд нь 20 гаруй гишүүнийг багтаан баталсан юм. Тэгвэл уг ажлын хэсэг өчигдөр хуралдаж, дэргэдээ дэд ажлын хэсэг байгуулжээ. Тодруулбал, хурал зохион байгуулах ажлын дэд хэсэг, бичиг хэрэг боловсруулах ажлын дэд хэсэг, санхүү хариуцсан ажлын дэд хэсэг болгон дотор нь багцалсан байна. Эдгээрээс хурал зохион байгуулах ажлын дэд хэсэг нь маргааш хуралдахаар болжээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Дугаарын 60 мөр

## Д.Трамп шиг зангарагтай бай л даа

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Харин энэхүү амлалт нь Д.Трамп гагцхүү “Аугаа Америкийг дахин сэргээнэ” гэх уриагаа ажил хэрэг болгож, дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө л ажиллах нь гэх итгэл үнэмшлийг сонгогчдод төрүүлсэн байж ч болох. Тэгвэл АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн үл хөдлөх хөрөнгийн магнат эдийн засгийн өсөлт нь саарсан улсынхаа төлөө ийнхүү цалингаа “хандивлаж” байхад, хэдийнээс зочломтгой зан, сайхан сэтгэлээрээ зартай Монголын парламент дахь тэрбумтан гишүүд сарын сая төгрөгийн цалинтайгаа зууралдсан хэвээр. Эдийн засгийн хямралд улс даяар нэрвэгдэж, төсөв нь мөнгөгүй, иргэд нь ажилгүй болж, өрх бүр идэх хоолоо граммлаж байхад эрхэм гишүүд нүүрэн дээрээ хямрал ярих атлаа бодит байдал дээр 200 сая төгрөгийн цагаар гоёж баярхах аж. Жирийн иргэдийн шинэ гурван өрөө байр, машин авах хэмжээний үнэ бүхий цагийг парламентын дөрвөн ч гишүүн зүүдэг гэнэ билээ. Үүгээр ч зогсохгүй жилдээ л тэрбум давсан орлого олдог хэд хэдэн гишүүн байдаг нь АТГ-аас гаргасан төрийн өндөр албан тушаалтны ХОМ-ээс ил болсон. Тодруулбал, жилийн 10 тэрбум төгрөгийн орлогоороо “Оргил” группын Ерөнхийлөгч бусад гишүүдээ түүчээлсэн бол дөрвөн тэрбумын орлогоороо ард түмнээ хэтэрхий тансаг хэмээн шүүмжилсэн Б.Дэлгэрсайхан гишүүн удаалах ажээ. Улмаар Ж.Энхбаяр, Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт нар дөрөв, Ц.Гарамжав гурав, С.Батболд, Н.Цэрэнбат нар хоёр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн 1.3, Б.Ундармаа нэг тэрбумын орлогоороо тус тус удаалж байгаа бол хэдэн зуун саяын орлогоороо З.Нарантуяа, Д.Дамба-Очир, Б.Баттөмөр, Д.Эрдэнэбат, Д.Оюунхорол нарын гишүүд баян гишүүдийн жагсаалтыг үргэлжлүүлнэ. Үүнээс гадна хадгаламждаа 20 хүртэл тэрбумтай Б.Наранхүү нарын гишүүд цөөнгүй. Улс эх орны эдийн засгийн байдал хүндэрч, дампуурах шахсан хувийн компанийн ажилчид цалингаасаа хүртэл татгалзаж байхад энэ мэт тэрбумтан гишүүд нүдэн балай чихэн дүлий мэт дүр эсгэх аж. Сонгуулийн сурталчилгаа ид өрнөсөн тэрхүү цаг үед тэднээс өөр эх орныхоо төлөө гэсэн сэтгэлтэй хүн байгаагүй л болов уу. Тэртэй тэргүй жилийн тэрбум давсан орлоготой тэдэнд гишүүний цалин тийм ч их мөнгө биш л байх. Хэрэв тэд Д.Трамп шиг зангарагтай байж, жилийн цалингаасаа татгалзчихвал, нэг гишүүнээс жилдээ хамгийн багаар бодоход 18 сая төгрөг хэмнэгдэнэ гэсэн үг. 30 гишүүн цалингаасаа татгалзлаа гэхэд 540 сая төгрөг хэмнэнэ. Энэ мэтээр гишүүд хэмнэлтээ өөрсдөөсөө эхлүүлж, улс төрийн соёл, цаашлаад тэрбумтны зангарагаа харуулаач. Магадгүй Д.Трамп шиг байж чадвал, хэдэн сая төгрөгийн үнэтэй цаг зүүж, цүнх барьж баярхсанаас ч илүү өөрт нь итгэл хүлээлгэсэн ард түмэнд гоё харагдах биш үү.

ҮЗЭЛ БОДОЛ

# МОНГОЛЫН ТӨР ДАХИАД Л ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГОО ХӨСӨР ХАЯЛАА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Гэр бүлийн хос гурав ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажлын байрыг хадгалж, хүүхэд асарсаны тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, улмаар түүний сарын цалингийн хэмжээнд хүргэнэ гэх мэт сайхан сайхан зүйл, заалт байгааг сайшаамаар байна. За тэгээд хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол болон бүрэн дунд боловсрол эзэмшихэд төрөөс бүхий л хөрөнгө мөнгөө зарцуулна гэж байл уу. Ямар болов. Өнгөрсөн дөрвөн жилд хүн амын өсөлт рүү чиглэсэн бодлого яриагүй биш ярьсан. Одоогийн УИХ-ын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам гэж байсныг толгойлж байсан сайд асан С.Эрдэнэ гурав дахь хүүхдийг дэмжих бодлого гээчийг баахан ярьсан. Гурав дахь хүүхдээ төрүүлбэл цалингийн доод хэмжээний 50 хувьтай тэнцэх цалин олгож байхаар бодлого хэрэгжүүлнэ гээд л байлаа.

Уг нь маш зөв бодлого. Ямар ч байсан зүтгэж байгаад энэ бодлогыг гаргаад, хэрэгжүүлсэн бол тун сайн байх байлаа. Тэглээ гээд айл болгон гурван хүүхэд ч л байсан цэцэрлэгээр дутаана гэж байгаагүй. Биелүүлсэн бол тун ч цогц бодлого. Гэтэл өнөөдрийг хүртэл юуг нь биелүүлэв. Аль заалт нь хэрэгжив. Аль нь ч хэрэгжээгүй. Төр хүн амын өсөлт рүү хандсан бодлогоо огт дэмжээгүй, хэрэгжүүлэхийг хүсэхгүй явсаар өнөөдрийг хүрсэн. Түүнээс нь болоод хүн амынөсөлтийнхурдзогсчихоод байна. Дээр дурьдсан баримт бичигт Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт 1986-2002 оны хооронд 2.8-1.4 хувь болтлоо буурсан. Энэ бууралт цаашид хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд 0.9 хувь болох төлөвтэй гээд биччихсэн байгаа. Төлөвсөөд байх юмгүй өсөлт буурч байгаа. 1990-2000 оны хоорон дахь 10 жилийн бууралт шиг “там”-д уначихаагүй байгаа ч хурдтай өсөх шинж алга. Өнөөдөр залуу гэр бүл дунжаар хоёр л хүүхэдтэй байна. Гэтэл сүүлийн үед гарч ирж байгаа эрх баригчид, Засгийн газар төрөлтийг дэмжсэн бодлогыг дандаа өрөөний мухарт хаях төрүүлдэггүй юм гэхэд маш их нөлөөлөх байлаа. Гэвч тэд хүн амын өсөлт рүү чиглэсэн бодлогоос мөнгө харамласан. АН-ынхны томчууд, эрх мэдэлтэн дунд хүн амаа өсгөхийг хүсдэг хүн байхгүй бололтой. Тэгвэл 2016 оны сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж, олонхи болсон. Тиймдээ ч дангаараа Засгийн газраа байгуулж, яамдуудынхаа нэрийг өөрчилж, сайд нараа ч томилсон. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны нэр өөрчлөгдөж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болчихоод байгаа. Хөдөлмөрийн яамыг нийлүүлээд хүн ам гэдэг үгийг аваад хаячихсан. Хүн амын тухай ярихгүй гэдгээ хэлснээс ялгаагүй л дээ. Энэ том салбарын сайдын суудалд Н.Номтойбаяр гэдэг залуу залрав. Яах вэ, сайн, муу янз бүрээр л хэлүүлж байна. Энэ хүний өнөөдрийг хүртэл хийсэн, хэрэгжүүлэхээр ярьж байсан бодлогуудын дундаас хамгийн их хүлээлт үүсгэж байсан нь “Цалинтай ээж” хөтөлбөр. Монгол Улсын нийт өрхийн 72.8 хувь нь 1-2 хүүхэдтэй. Иймээс нэг өрхөд ногдох хүүхдийн тоог нэмэгдүүлэх, олон хүүхэдтэй өрхийг дэмжих нь зүйтэй гэж Засгийн газраас үзэж, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байлаа. Эхэндээ0-3насныхүүхдээасарч байгаа эхэд улирал бүр цалин олгохоор ярьж байсан. Сүүлдээ сар бүр өгөхөөр болсон. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр эхчүүд улирал бүр 240 мянган төгрөг авах боломжтой гээд л сайд нь ярьж байлаа. Ингэхдээ 0-3 насны хүүхдээ хараад гэртээ сууж байгаа эхэд өгөх юм уу, эсвэл энэ насны хүүхэдтэй ээж болгон авах уу. Гурав дахь хүүхдийг дэмжих бодлого нь юу юм гэх мэтээр маш олон зүйл тодорхой биш ч ээжүүд энэ хөтөлбөрийг хүлээж байна. Уг нь ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гэж байсан. Харамсалтай нь Монгол Улсын төр дахиад л хүн амын өсөлтийг дэмжих бодлогоо хаялаа. Бүр хөсөр хаялаа. Дахиад шүү. Өнөөдөр хүүхэд бүрт 20 мянган төгрөг өгч байгаагаа хүн амын өсөлтийг дэмжих бодлого гэж гүжирдээд байдаг. Хүүхэд бүрт ч гэж дээ, 60 хувьд нь өгч байгаа. Энэ бол үнэндээ хүн амын өсөлтийг дэмжих бодлого биш шүү дээ. Харин “Цалинтай ээж” хөтөлбөрийг бол хүн амын өсөлтийг дэмжсэн бодлого гэж хэлж болно. Мэдээж цогц бодлого бол биш. Зүгээр л хүүхэд төрүүлэхийг дэмжинэ, эхчүүдэд үр хүүхдээ өсгөх 2-3 жилд нь цалин өгье л гэдэг хөтөлбөр. Хүүхэд цэцэрлэгт орох үед яах вэ, цаашлаад дунд сургуульд орох үед яаж дэмжих үү. Цэцэрлэгийн хүрэлцээг яаж шийдэх юм гээд олон асуудал тодорхой биш. Хэдий дутуу ч оргүйгээс дээр хөтөлбөр байлаа. Харамсалтай нь МАН-ын Засгийн газар, УИХ энэ хөтөлбөрөөс төсөв харамлав. Өөр олон янзын хөтөлбөрт төсөв баталж өгчихөөд ээжүүдээс харамлаж. Хамгийн наад зах нь маш өндөр төлбөртэй сургуулиудад гэхэд 25 тэрбум төгрөгийн хувьсах зардал төсөвлөсөн. УИХ-ын гишүүд ч өөрсдөө хэлж байна. Жилдээ 4-8 сая төгрөгийн төлбөртэй 20 цэцэрлэгт улсаас хувьсах зардал нэрийдлээр 1.3 тэрбум төгрөг өгөх гэж байна. Төрийн ордныг засна гээд л хэдэн тэрбумаар төсөвлөдөг. Гэх мэтээр Засгийн газар хайр найргүй хэдэн тэрбумаар нь мөнгө үрж байна. Дээрхтэй адил гайхмаар янз бүрийн зардлууд маш их байгаа гэж... Гэтэлягаадхүнамынөсөлтрүү чиглэсэн бодлогоосоо мөнгө харамлаад байгаа нь гайхмаар. Бусад элдэв янзын халамжийг халаад, зөвхөн “Цалинтай ээж” рүүгээ мөнгө өгсөн ч яадаг юм. Болиулчихмаар хэрэгтэй хэрэггүй хөтөлбөрүүд зөндөө л байна. Оюутны 70 энэ тэр гээд л. Түүний оронд хүн амаа өсгөхөд чиглэсэн бодлогоо хэрэгжүүлье л дээ. Монгол Улсын хүн ам 2-3 сая хүртэл 30-аад жилийг зарцуулсан. Одоо 3-4 сая хүртэл дахиад л 30 жил зарцуулах уу. Хүн ам 4-5 саяд хүрчихвэл улс төртэй, төргүй хөгжчихнө.

> ...Харамсалтай нь МАН-ын Засгийн газар, УИХ энэ хөтөлбөрөөс төсөв харамлав. Өөр олон янзын хөтөлбөрт төсөв баталж өгчихөөд ээжүүдээс харамлаж. Хамгийн наад зах нь маш өндөр төлбөртэй сургуулиудад гэхэд 25 тэрбум төгрөгийн хувьсах зардал төсөвлөсөн. УИХ-ын гишүүд ч өөрсдөө хэлж байна. Жилдээ 4-8 сая төгрөгийн төлбөртэй 20 цэцэрлэгт улсаас хувьсах зардал нэрийдлээр 1.3 тэрбум төгрөг өгөх гэж байна...



ЦАГ ҮЕ

ЯРИЛЦАХ ТАНХИМ

# М.ЛХАЧИНБАЛ:

Э.ТУУЛ

*Тэртээ 1946 онд нийслэлчүүдийг мах, махан бүтээгдэхүүнээр хангах чиг үүрэгтэй “Боловсон мах комбинат” байгуулагдаж байсан түүхтэй. Тэгвэл Монгол Улсын хүнсний ууган үйлдвэр, “Боловсон мах комбинат” буюу эдүгээгийн “Мах Импэкс” ХК-ийн 70 жилийн түүхт ой энэ онд тохиож буй. Тиймээс энэ удаагийн “Чухал хүн” буландаа “Боловсон мах комбинат”-д цэл залуу 25 насандаа хөл тавьж, энэ байгууллагыг удирдаж явсан ахмад ажилтан М.Лхачинбал гуайг урьж, ярилцлаа.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## “МАХ ИМПЭКС” БОЛ МОНГОЛ УЛСАД МАХНЫ АЖ ҮЙЛДВЭР ҮҮСЧ ХӨГЖИХ ЭХЛЭЛИЙГ ТАВЬСАН АНХНЫ ГАРААНЫ ҮЙЛДВЭР

**-Таны энэ өдрийн амгаланг айлтгая. Төрөлх үйлдвэрийн тань түүхт 70 жилийн ой тохиож байна. Энэ хамт олонтой хөл нийлж, ажлын гараагаа эхлүүлсэн тэр сайхан он жилүүдээ эргээд нэг дурсахгүй юу?**

-Би олон жилийн турш энэ хамт олонтой амьдралаа холбосон. Эндээс л ажил, амьдрал маань эхэлсэн учраас энэ хамт олныг мартах ёсгүй. Үйлдвэр дээрээ ирэх болгондоо баяртай байдаг. Өнөөдөр бас хамт олон маань урьж, энэ том хэвлэлийн сэтгүүлч ярилцлага авч байгаад их баярлаж байна. Тэртээх 1970-1980 он бол Монгол Улсад аж үйлдвэр хөгжсөн, тэр дундаа хөнгөн хүнсний аж үйлдвэр хөгжсөн эрчимтэй жилүүд байсан. Үүнийг дагаад үйлдвэрүүдээ боловсон хүчнээр хангах улсын бодлого ч явагдаж байв. Тэр үед буюу 1965 онд аравдугаар анги төгсөөд энд тэндээс ирсэн 25 охид, хөвгүүдийг Хөнгөн хүнсний үйлдвэрийн яамнаас хүнсний үйлдвэрийн чиглэлээр мэргэшүүлэхээр ЗХУ, одоогийн Украйны Одесс хотын Хүнсний дээд сургуульд явуулж байсан юм. Тэр дотор миний бие багтсан юм. Би Баянхонгор аймгийн арван жилийн сургууль төгсөөд ирээд байсан. Тэгээд бид 25-уулаа очиж, сургуульдаа суралцсан. 25 хүүхдээс дөрөв нь янз бүрийн шалтгаанаар сургуулиа төгсч чадаагүй. Харин 21 нь 1970 онд сургуулиа төгсч ирсэн. Биднийг төгсөөд ирэх үе буюу 1970 он гэдэг бол үйлдвэр маань хүчин чадлаа нэмэгдүүлчихсэн, тухайн үеийн БНАГУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар үйлдвэрийн шинэ өргөтгөлөө хүлээж аваад аль хэдийнэ хөл дээрээ тогтчихсон байсан үе л дээ. Харин хоёр дахь ээлж буюу Хиам консервны үйлдвэр, Консервын цех ид баригдаж байсан юм. Үндсэндээ ашиглалтад орох гээд барилга байшин нь баригдаж байсан үе байлаа. Ингээд бид зургуулаа хуваарилагдаж ирж байсан юм. Ер нь биднийг ажилд томилохдоо хамгийн доод шатнаас нь эхлүүлж, бүх арга ажиллагаанд сургаж, шат ахиулдаг байсан шүү.

**-“Мах импэкс” ХК-ийн 70 жил гэдэг Монгол Улсад махны аж үйлдвэр үүсч хөгжсөн ой гэж ойлгож болох уу?**

-Тийм шүү. Энэ компани бол Монгол Улсад махны аж үйлдвэр гээч юм үүсч хөгжсөн анхны гарааны үйлдвэр байхгүй юу. Тийм учраас энэ үйлдвэрийн түүх бол Монгол Улсад махны аж үйлдвэр үүсч хөгжсөний 70 жилийн түүхтэй давхцаж явдаг. “Боловсон мах комбинат” 1971-1975 он хүртэл үндсэндээ цор ганцаараа Монгол Улсын нийт хэрэглэгчдийг мах, махан бүтээгдэхүүнээр хангаж ажиллаж байсан, ийм л том далайцтай үйлдвэр. Өөрөөр хэлбэл, Монголын бүх аймгийн мал сүрэг тэр үед энэ үйлдвэр дээр л төвлөрч байсан. Цэрэг арми, эмнэлэг, сургууль гээд хаана л мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ байна, тэр бүхнийг энэ үйлдвэр ганцаараа нуруун дээрээ үүрч ирсэн. Түүнээс хойш буюу 1972 онд Дорнод аймгийн төв Чойбалсанд нэг үйлдвэр, 1973 онд Дарханд нэг үйлдвэр ашиглалтад орсон. Ингээд 1974, 1975 оноос гурван үйлдвэр ажиллаж, ачаагаа хуваалцах болсон юм. Тэгэхээр энэ үйлдвэр бол Монголд махны аж үйлдвэр үүсч, хөгжсөн түүхийг бичилцсэн, тэр бүхнийг туулж өнгөрүүлсэн ийм л сайхан хамт олон доо.

**-Таны хувьд энэ том үйлдвэрийнхээ аль цехэд анхлан хөл тавьж байв?**

-Энд чинь Арьсан цех гэж нэг их том хэсэг байдаг байлаа. Тэр цехэд малын арьс, ширний анхан шатны боловсруулалтыг хийгээд чанарыг нь хамгаалаад давслаад бэлддэг байсан юм. Тэгсэн намайг очдог жил тэр цехийн мастер Бат-Өлзий Чех улс руу эмчилгээнд явж таараад, өнөөх төгсч ирсэн хүмүүсээс намайг салгаж аваачаад, Бат-Өлзийгийн оронд түр мастераар тавьчихгүй юу. Өмнө нь ажиллаж үзээгүй болохоор юу ч мэдэхгүй хүн очиж байлаа. Гэтэл тэр цехэд цэргээс халагдсан баахан залуучууд, хэсэг авгай, хүүхнүүд. Хоригдлууд бас байдаг байсан юм, тэр үед. Ингээд л тэдэн дунд орчихсон. Тэгээд ажил хий гэж байхад хийхээс өөр яах вэ дээ. Хэсэг л наред бичих, цагийн бүртгэл хөтлөхөөс эхлээд цаасны ажил хийлээ. Мөн ажлаа хуваарилна, зохион байгуулна. Ингээд л эхэлж байсан юм. Тэгтэл есдүгээр сард Бат-Өлзий эмчилгээнээсээ ирээд, ажилдаа орлоо. Яг тэр үед намайг Өлөнгийн цехэд ажилчнаар өгсөн юм. Тэгээд би чинь Өлөнгийн цехэд тооцоологчоор ажиллаж эхэллээ. Тэр Экспортын цех гэдэг чинь богийн олон гэдсийг машинаар оруулаад бүр цэвэрлэнэ. Цэвэрлээд гараад ирснийг нь тоолж арав, арваар нь багцлаад сортоо хийнэ гээд л тэгээд гурван диспетчертэй байдаг байсан юм. Одоо би бол гурван диспетчерээ санаж байгаа ш дээ, хөөрхий минь. Муу талийгаач Мижид гуай, Юрка, хар Машка гурав. Бид тоглоод манай гурван аварга гэдэг байсан юм. Тэр гурав чинь 24 цагаар жижүүр хийнэ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрийн 24 цагийн манаа байхгүй юу. Диспетчер гэдэг маш чухал. баахан цагаан халадтай хүүхнүүд байдаг. Сортолсон өлөнгөө хүн нэг бүрчлэн гарын үсэг зурж, хүлээлцэж авна шүү дээ. Учир нь хүн болгон дээр гарцыг нь тооцдог болохоор маш нарийн хүлээлцэнэ. Тийм ажил хийж байсан даа. Тэр нь хамгийн хялбар, миний хийж чадах ажил байхгүй юу. Тэгээд би 1970 оныг дуустал тооцоологчоор ажиллаж байгаад 1971 оноос Өлөнгийн заводод технологичиор тавьсан юм. Өлөнгийн завод гэдэг чинь 300 гаруй ажиллагсадтай бас их том үйлдвэр ээ, их чухал. Бод, богийнхоо өлөнг боловсруулна. Орон нутгаас хэчнээн их өлөн ирнэ гээч. Ерөөсөө бүх л газраас зөвхөн тэр үйлдвэр дээр л ирдэг байсан юм. Бүтэн жилийн турш, зогсоо чөлөөгүй ажилтай, их том үйлдвэр байсан. Тэнд технологичоор ажиллаад нэг жил болоод даргынх нь албыг авсан. Намайг ажиллаж байх үед дарга нь Батнасангийн Чимид гэж настай нэг их сайхан авгай, олон жил ажилласан туршлагатай хүн байсан. Тэр хүн тэтгэвэртээ суугаад намайг оронд нь тэр үйлдвэрийн даргаар тавьсан юм. Ингээд 1972-1974 он хүртэл ажилласан даа.

**-Тэр үед хамт ажиллаж байсан олон сайхан залуус тань эдүгээ ахмад буурлууд болсон яваа. Тэр сайхан хамт олноосоо дурсахгүй юу?**

-1974 онд ерөнхийдөө үйлдвэрийн ажил ихсээд, томроод бүтэц зохион байгуулалтаа хүртэл өөрчилж эхэлсэн. Тэр жил Үйлдвэр төлөвлөгөөний хэлтэс гэж шинээр байгуулагдлаа. Төлөвлөгөөний хэлтэс, Үйлдвэрийн хэлтэс гэж хоёр хэлтэс байсныг нийлүүлээд Үйлдвэр төлөвлөгөөний хэлтэс гэж болгосон юм. Тэгээд намайг даргаар нь тавилаа даа. Тэндээ хэдэн сайхан улсуудтай. Манай муу талийгаач Ганбаа гуай, Баатар гэж сайхан өвгөн байсан. Баатар гуай энэ үйлдвэрт насаараа ажилласан, дээр үед комбинатын дарга хүртэл хийж байсан. Сургууль төгсөөгүй ч, статистик, эдийн засгийн мэдээ гаргана. Бүх статистикийн мэдээг гаргадаг. Тэгэхдээ ерөөсөө тэр тоо алдана гэж байхгүй, их нягт нямбай хүн байж билээ. Сандагдорж гээд жинхэнэ сургууль төгссөн эдийн засагч, дороо нэг технологичтой, Ёстой биднийг байх, байхгүйд шөнө орой бол үйлдвэрийн бүх явцыг хянана. Ийм л Үйлдвэр төлөвлөгөөний хэлтэст би 1975 он хүртэл ажилласан. Хоёр жил бүтэн ажиллахдаа их зүйл сурсан. Үйлдвэрийг ерөнхийд нь удирдах зангидах, дээрээс нь хамгийн гол нь эдийн засгийн төлөвлөлт, статистикийн мэдээ гаргаж сурах чинь технологийн инженер хүнд бөөн олз байхгүй юу. Тэгээд өртгийн тооцоо хийх гэх мэтчилэн бүх л зүйлийг хийдэг байлаа. Мөн энэ дундаас онцлоход манай Хөргөх үйлдвэрийн дарга Хандын Пүрэвдорж гэж залуу байсан. Энэ хүн бол гадаад, дотоодын сургууль төгсөөгүй. Ерөөсөө долдугаар анги л төгссөн. Тэгэхдээ төрөлхийн оюуны чадвартай, хүнтэй ажиллах ур дүйтэй, ажил зохион байгуулах ур чадвартай, хүнд хэлснээрээ байж чаддаг хүн байсан юм. Маш сайн дарга байсан. Ерөөсөө энэ махны том үйлдвэрийн амин сүнс бол Хөргөх үйлдвэр. Тэр Хөргөх үйлдвэр л маш сайн ажиллахгүй бол нөгөө үйлдвэр, цехүүдийн үйл ажиллагаа доголддог. Тухайн үед Хөргөх үйлдвэр бас нэг хэсэг биднийг зовоодог байсан юм. Нөгөө мах шөл нь багтахгүй, түргэн хугацаанд хөлдөөж чадахгүй, коридороороо нэг мах, дотор эрхтнээ зулчихсан, заваардаг юм зөндөө л байдаг байсан. Тэгэхэд Пүрэвдорж Хөргөх үйлдвэрийн дарга болсон. Түүнээс хойш л сайхан болгож өгсөн дөө. Эмх цэгцэнд нь оруулаад, сайхан болгосон. Нэг эмх цэгцэнд нь оруулаад өгсөн юм дараа дараачийн үедээ эвдэрдэггүй байхгүй юу. Мах хураах чинь хүртэл урлаг, технологи шүү дээ. Тэр гоё урлагтай хураасан юм чинь агуулахын багтаамжаа хүртэл эмх цэгцтэй болгож байгаа юм. Тухайн үед үйлдвэрүүдээс Хангамж борлуулалт эрхэлсэн орлогч даргад ганцхан энэ Хөргөх үйлдвэр захирагддаг байсан. Би яагаад Пүрэвдоржийг яриад байна вэ гэвэл ерөөсөө хамгийн хүнд, цаг хугацаа шаардсан ажлаа би Пүрэвдорждоо л даалгана. Пүрэвдорж ямар гоё гүйцэтгэнэ гээч. Гүйцэтгэл гэж янзын гайхалтай тийм л хүн байсан. Пүрэвдоржоо чи энэ ажлыг ингээд хийгээрэй гэхэд за гээд л гарсан бол дахиж араас нь асуух ч хэрэг байхгүй. Санаа зовох ч хэрэг байхгүй. Тийм залуу байсан байхгүй юу. Тэгж юмыг хийдэг, тэгж зохион байгуулдаг. Гэх мэтчилэн дурьдаад байвал олон сайхан залуустай гар, сэтгэл нийлж, олон ч жил сайхан ажилласан даа.

**-Та тэндээсээ Хиам, консервны үйлдвэрийн даргаар томилогдсон юм уу?**

-Овоо ажилдаа гаршаад байж байтал үйлдвэрийн удирдлагууд намайг Хиам, консервны үйлдвэрийн даргаар тавьчихдаг байгаа. Тэр үед чинь удирдлагуудын гарын далайцаар л явдаг байлаа шүү дээ. Тэгээд 1975-1977 он хүртэл Хиам, консервны үйлдвэрийн даргаар ажилласан. Гэтэл 1977 онд яамнаас дууддаг юм байна. Очсон чинь Хөнгөн хүнсний үйлдвэрийн яам Мах, сүүний үйлдвэрийн хэлтсийг шинээр байгуулсан, хэлтсийн даргаар нь ажилла гээд шинэ хэлтсийн анхны даргаар томилогдсон юм. Ингээд л Төв хороогоор оруулж, батлуулаад хэлтсийн дарга болж байлаа. 1977-1982 он хүртэл Мах, сүүний үйлдвэрийн хэлтсийн даргаар ажиллаж байтал 1982 онд намайг буцаагаад Мах комбинатын орлогч даргаар очиж ажилла гээд томиллоо. Тэгэхэд чинь Жааяа /Жамъянсүрэн/ дөнгөж дарга болж байсан юм. Уг нь Жааяа миний томилогдож очсон ажлыг хийж байсан юм. Тэгээд л хангамж, борлуулалт хариуцсан орлогч дарга боллоо. Түүнээс хойш бид олон жил сайхан ажилласан даа. 1982-1990 он хүртэл их ачаалалтай он жилүүд байсан. Ер нь 1989 онд ирсэн. Тамхи нь задгай, том том цаасан хайрцагт савлачихсан. Хөвөн нь түнтгэр боодолтойгоо байгаа юм. Тэр бидэнд их хэрэг болсон шүү, тухайн үед. Тэгээд би Хятадаас жижигхэн уут авч ирээд ажилчдаараа нөгөө улаан тамхиа 500 гр-аар савлуулаад, хүүхдийн үс боодог резинээр амыг нь боолгоод л мал хөөцөлдөх гэж хөдөө явахаараа аваад явна. Нэг хэсэг л малчдыг тамхи, хөвөн, цаасаар хангасан даа. Тухайн үед тийм чухал бараатай байгууллага нь манайх л байсан. Сүүлдээ баахан буу, сум оруулж ирсэн. Тэгээд малчидтай өнөөхөө малаар солиод л, ажлаа явуулдаг байлаа. Ер нь тэгээд юу эсийг хийх вэ дээ. Ингэж байтал эвээ олоод ирсэн. 13 аймагт мал, түүхий эд бэлтгэлийн газар байгууллаа. Өөрөөр хэлбэл, нөгөө байхгүй болсон мал бэлтгэлийн системийг шууд компани өөрийнхөө хүчин чадлаар байгуулахгүй юу. Тэгээд тэндээ дарга цэрэг, нягтлан гээд л бүх боловсон хүчнийг нь тавиад, сүүлдээ малаа өсгөх даалгавар өгөөд 1998 онд би ажлаасаа явж байхад компанидаа 100 гаруй мянган малтай болсон байсан. Хамгийн их мал өсгөсөн нь. Өвөрхангайн Түдэврэнцэн гэдэг малчин байсан юм. Тэр үед Дэлэг захирал бидэнд ярьж байсан юм. За нэг сая орчим бог малтай, 100 мянган бодтой болчих юм бол малчдын царай харахгүй гээд л. Том юм ярьж байгаа биз. Тэгээд түүнийгээ дагуулаад малчдыг уруу татаад малыг нь аваад ирэх юм байна даа гэж тооцож, ажиллаж байсан юм. Уг нь бидний бий болгосон рекорд тогтоож байсан байгаа юм шүү дээ. Одоо статистик мэдээллийг нь харах юм бол хамгийн их үйлдвэрлэл явуулж, хамгийн их экспорт хийж байсан үе нь 1989 он. Тийм л их ажилтай, сайхан үед нь бид хамтарч сайхан ажиллаж байсан. Тэгээд 1990 онд Жамъянсүрэн маань ажлаа өгч байсан юм.

**-1990 он гэдэг зах зээлийн нийгэмд шилжээд, үйлдвэрүүдэд их хүнд үе тохиож байсан юм шиг байгаа юм. Тэр үед та даргаар томилогдсон байдаг?**

-Ер нь 1990 он гэдэг бол хүнд үе байсан. Малчид малаа хувьчилчихсан. Хуучин мал бэлтгэлийн систем ерөөсөө байхгүй болчихсон. Энэ Мах комбинат цаашдаа яаж ажиллах юм бэ гэдэг цоо шинэ даалгавар гарч ирэхгүй юу. Яг тэр үед Жамъянсүрэн намайг орондоо энэ компанийн захирлаар тавиулах гээд Дэлэг захиралд хэлсэн байдаг юм. Жавзмаа гэж Хотын намын хорооны Үйлдвэр эрхэлсэн орлогч дарга байсан юм. Жавзмаа дарга байсхийгээд л намайг дуудна. “За цаад Жамъянсүрэн чинь чамайг томил гэж байна. Цаадах чинь Хотын намын хороонд өргөдлөө өгсөн. Би өөр ажил хийнэ. Амиа бодно” гээд байна гэдэг юм. Тэгэхэд нь би ерөөсөө зөвшөөрөөгүй. Тэгээд би хоёр сар Орос руу томилолтоор явахгүй юу. Тэр үед чинь Консервны цех бараг зогсч байсан. Яагаад гэвэл консервны лааз дуусчихсан. Бас бус асуудал зөндөө. Хуучин бид чинь гадаад захиалга хийгээд л яамандаа өгчихдөг. Яам төвлөрсөн зохион байгуулалтаар гэрээ хийгээд, гэрээний дагуу нийлүүлэгдээд байдаг байсан юм. Гэтэл тэр асуудал байхгүй болоод өөрсдөө яв гэж эхэлсэн. Тиймээс би энэ асуудлаа хөөцөлдөх гээд явсан байхгүй юу. Хоёр сар ОХУ-д үйлээ үзсэн. Галт тэргэнд суугаад ганцаараа ийшээ, тийшээ яваад л. Тэр үед ЗХУ бас хөл толгойгоо олохоо байчихсан үе. Ерөөсөө тэр үед бүх юмыг нь Москва атгачихсан. Нөгөө үйлдвэрүүд нь ямар ч эрх мэдэл байхгүй. Учраа олохоо байчихсан. Тэгээд үйлээ үзэж үзэж, би 1000 тонн лаазны гэрээ хийж ирсэн. Дээрээс нь Киргизээс 100 тонн улаан тамхи, хуйлаатай цаастай нь, Узбекээс 50 тонн хөвөн дарж тэр монтаж, схемийг алдахгүй л явах ёстой байсан болովч сүүлдээ алдсан даа. Одоо бодоход тэр л их харамсалтай санагддаг юм.

**-Тэгэхдээ л тэр хүнд үеүд аль хэдийнэ ард хоцорч, эдүгээ “Мах импэкс” ХК 70 жилийн түүхт ойгоо тэмдэглэх гэж байна. Залуус та бүхний хийж гүйцэтгэж байсан тэр сайхан ажлыг өнөөдөр хүртэл үргэлжлүүлээд, Монголдоо бүү хэл Азидаа анхдагч болоод явж байна шүү дээ. Та үйлдвэрийнхэндээ хандаж, сэтгэлийн үгээ хэлэхгүй юу?**

-Тэгэлгүй яах вэ. Одоо бол сайхан байна. Үйлдвэр маань өргөжөөд, улам сайхан тэлээд, мах, махан бүтээгдэхүүн, хиамныхаа үйлдвэрийг их сайхан болгож. Боловсруулах чиглэл рүүгээ техник технологио сайжруулаад, савлагаа энэ тэрээ сайхан болгоод явж байгаа нь баярлууштай. Ер нь мал байна уу байна. Мах байна уу байна. Одоо тэр боловсруулах технологи тал руугаа анхаарч байгаа нь маш зөв гэж би бодож байгаа. Гэхдээ нөгөө талаа бол бас бодох хэрэгтэй. Цаашид хүнсний аюулгүй байдал их хурц яригдана. Экспортын асуудал, аюулгүй байдал талаасаа одоохондоо хүндрэлтэй байна. Ийм нөхцөлд маш тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй. Залуучууд маань хүч хөдөлмөр гаргах байх гэж би бодож байна. Мөн энэ жил “Мах импэкс” компанийн маань 70 жилийн түүхт ой болж байна. Энэ ой бол ганц энэ компанийн ой биш, энэ бол Монгол Улсад махны аж үйлдвэр үүсч хөгжсөний 70 жилийн ой. Тиймээс компанийн маань ойд салбарын яам их өндөр ач холбогдол өгч, оролцож ажиллаж байгаа байх гэж би бодож байна. Манай хамт олон түүхт ойгоо олон сайхан амжилтаар угтаж байна. Дахиад улам их өндөр амжилт гаргаасай гэж миний хувьд хүсч байна. Бүтээгдэхүүний чанар чансаа, нэр хүнд улам өсч байна. Ер нь монголчууд “Мах ммпэкс”-ийнхээ л бүтээгдэхүүнийг хэрэглэе, авъя гэдэг болсон байна. Тэгэхээр энэ үйлдвэрээс ажлын гараагаа эхэлсэн, энд ажиллаж байсан үй олон найз нөхөд, хамт олондоо баярын мэнд хүргэж, бүгдэд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

# АХМАДУУДАА ХООСОН ҮЛДЭЭСЭНГҮЙ, ГЭХДЭЭ...

## Эсрэг тэсрэг байр суурь

## Б.Чойжилсүрэн: Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байгаа



...Гаргаж чадаж байгаа эх үүсвэр нь 20 орчим тэрбум төгрөг. Үүндээ тохируулаад мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлье гэж байна. Эдийн засаг гайгүй болсон нөхцөлд бүх хүүхэд, бүх ахмаддаа олгоод явах бодлого баримтална. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байгаа санаа...

*/Сангийн сайд/*

-Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар өндөр насласан хувь хишиг болгон “Насны хишиг” олгож байгаа. Ингэхдээ 65-69 насныханд жилд хоёр удаа 50. 70-79 настанд жилд хоёр удаа 80. 80-89 насныханд жилд хоёр удаа 150, 90 ба түүнээс дээш өндөр настнуудад жилд хоёр удаа 250 мянган төгрөг олгоно. Энэ шийдвэрийн дагуу 121 905 ахмад настанд 20 тэрбум төгрөг өгөхөөр төсөвлөгдсөн байгаа. “Насны хишиг” шүүмжлэл дагуулж байгаа нь үнэн. Гаргаж чадаж байгаа эх үүсвэр нь 20 орчим тэрбум төгрөг. Үүндээ тохируулаад мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлье гэж байна. Эдийн засаг гайгүй болсон нөхцөлд бүх хүүхэд, бүх ахмаддаа олгоод явах бодлого баримтална. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байгаа санаа.



## Д.Оюунхорол: “Насны хишиг”-ийг ахмадууд баяртайгаар хүлээн авч байна

*/УИХ-ын гишүүн/*

-Иргэдтэй нэлээд олон уулзалт хийлээ. “Насны хишиг”-ийг ахмадууд маш их баяртайгаар хүлээн авч байгаа. Цагаан сараар, наадмаар гээд жилдээ хоёр удаа гэр бүлийн баяр хийх нь гээд. Учир нь ээж, аав нь урт насалсаныхаа төлөө, үр хүүхэд нь эцэг, эхээ урт наслуулсаныхаа төлөө авч байгаа гэр бүлийн зардлыг хуваалцаж байгаа гоё баяр, аятайхан агуулгатай мөнгө. Тиймээс ч “Насны хишиг” олгож байгаад баярлаж байна гэж байгаа. Энэ хуулийг маш их дэмжсэн.

## Г.Аким: Ахмадууд ҮХЦ-д хандсан ч хүлээж аваагүй



...Тэтгэвэр бол бидний насан туршдаа хуримтлуулсан хувийн өмч. Энэ өмч хөрөнгийг өвлүүлэх эхний алхам нь Хамтын тэтгэврийн тухай хууль байсан. Үүнийг шинэ засаг гараад хүчингүй болгож болохгүй. Тэгээд ч ахмадуудад өгөх тэтгэврийг “Насны хишиг” гэж нэрлээд байх юм...

*/МУСГЗ, доктор, профессор, нэрт дуун хөрвүүлэгч/*

-Хамтын тэтгэврийн тухай хууль баталсан нь олон хүнд тустай, амьдралд хэрэгтэй хууль болсон. Гэтэл шинэ Засгийн газар байгуулагдаад өмнөх парламентын баталсан сайн хуулийг цуцаллаа. Түүнийхээ оронд “Насны хишиг” өгөхөөр болж байгаа юм байна. Ахмадууд бид залуу насандаа улс, эх орныхоо төлөө хийж, бүтээж, түүнээсээ татвар төлдөг байсан. Гэтэл ихэнх нь тэтгэврийн насанд хүрч чадалгүй, эс бол цөөн хэдэн жил тэтгэвэр аваад хорвоогийн мөнх бусыг үзүүлдэг. Хамтын тэтгэврийн тухай хуулиар тэтгэврээ авч чадахгүй хүмүүс ар, гэр, хань ижилдээ өвлүүлэн үлдээх боломжтой байсан. Гэтэл энэ хуулийг хүчингүй болгож байгаа нь Үндсэн хуулийн гурван заалтыг зөрчиж байна гэж үзээд хэсэг ахмадууд Үндсэн хуулийн Цэцэд хандсан. Тодруулбал, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүлийн 19.1-ийг зөрчсөн учраас ҮХЦ-д хандсан. Гэвч ҮХЦ хүлээж аваагүй. Тиймээс энэ хэвээрээ “Насны хишиг” нь олгогдоод явах бололтой. Уг нь сонгуулийн үр дүнгээр төр засаг солигдох нь хамаагүй ганцхан төрийн залгамж чанартай, өмнөх засгийнхаа хийж хэрэгжүүлж байсан зөв, зүйтэй ажлыг үргэлжлүүлэх ёстой. Улстөрчдийн үл ойлголцол, залгамж чанаргүй байдлын золиос ард түмэн болох ёсгүй. Тэтгэвэр бол бидний насан туршдаа хуримтлуулсан хувийн өмч. Энэ өмч хөрөнгийг өвлүүлэх эхний алхам нь Хамтын тэтгэврийн тухай хууль байсан. Үүнийг шинэ засаг гараад хүчингүй болгож болохгүй. Тэгээд ч ахмадуудад өгөх тэтгэврийг “Насны хишиг” гэж нэрлээд байх юм. Гэтэл хишиг гэдэг үг чинь хүнд өөрөөсөө зүгээр бэлэг өгөхийг хэлдэг. Гэтэл МАН-ын өгөх гээд байгаа энэ мөнгө чинь бидний төрд зээлүүлсэн эргүүлээд авч байгаа хэлбэр. Харин эргүүлээд төлөхдөө хишиг хүртээж байна гэдэг маягаар өгч байгаа. Бодвол хишиг гэхээр л хөөрхий ахмадуудыг төр минь хишиг хүртээлээ гээд шогширно гэж ойлгосон байх. Бид чинь тэнэг хүмүүс биш, ойлгоно.



## Л.Болд: Манжийн хаан л хишиг олгодог байсан, харин МАН-ын дарга нар...

*/УИХ-ын гишүүн/*

-Ахмадуудаа ялган хэрэггүй. Хамтын тэтгэврийн хуулийг хүчингүй болгосондоо шатаад “Насны хишиг” гэж зүйл гаргаж ирсэн. Үр удмаар нь хэлмэгдүүлдэг зүйл энэ Засгийн газрын үед эргэн ирж байна. Манжийн хаан л хишиг олгодог байсан юм шүү. Одоо харин МАН-ын дарга нар ноёдын дүрд хувиран, хишиг тараах юм байна. Энэ нь ахмадуудыг азтай, азгүйгээр нь хувааж байна.

## Сэтгүүлчийн дүгнэлт

# НҮГЛИЙН НҮДИЙГ ГУРИЛААР ХУУРСАН УУ

Ж.ОТГОН

Өмнөх парламентын баталсан Хамтын тэтгэврийн тухай хуулийг шинэ парламент хүчингүй болгосон. Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол үзэл санаа нь тухайн ахмад настан өөрөө болон ажиллаж байсан аж ахуйн нэгж нь тухайн хүнд ноогдох шимтгэл хувийг төлөх замаар насан туршдаа хуримтлал бий болгож байгаа. Нэг үгээр хэлбэл ирээдүйд учрах аливаа эрсдлээс хамгаалах зорилгоор бий болгож байгаа тэтгэврийн хуримтлалын сан. Ахмадууд тэтгэврийн хуримтлалын сангаа насан туршдаа бий болгочихоод түүнийхээ үр шимийг үзэлгүй бурхны оронд яваад өгч байгаа тохиолдол цөөнгүй бий. Гэтэл бусад улс оронд бол энэ нь өвлөгддөг, тодорхой хувиар гэр бүлд нь очдог гэх мэт янз бүрийн хувилбар байдаг. Харин манай улсад болохоор тухайн даатгуулагч нас барахад түүний бий болгосон хуримтлал дундын санд үлдчихдэг. Тиймээс ч хамтын тэтгэврийн тухай хуулийг баталсан гэдэг. Тэгвэл Хамтын тэтгэврийн тухай хуулийг шинэ парламент хүчингүй болгосон. Энэхүү үйлдэл нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж ахмадууд ҮХЦ-д хандсан ч цэц хүлээж аваагүй юм.

Улмаар үүний оронд Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрт Ач санах хууль баталж, азай буурлууддаа “Насны хишиг”олгохоор болсон. Өөрөөр хэлбэл, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах асуудлыг УИХ-аар хэлэлцсэн. Хуулийн төсөлд ахмадуудад олгох “Насны хишиг”-ийг 70 наснаас олгох байсныг 65 наснаас эхэлж олгохоор болсныг гишүүдийн олонхи дэмжсэн юм. Энэ нь төсөвт хүндрэл учруулахгүй гэдгийг гишүүд онцолж байгаа. Төсөвт “Насны хишиг”-ийг олгоход 21 тэрбум төгрөгийг суулгаж өгсөн байгаа аж. Тиймээс ахмадуудад Цагаан сар, Үндэсний баяр наадмын өмнө “Насны хишиг”-ээ авна. Ингэхдээ 65-69 настай ахмадуудад 50 мянга, 70-79 настанд 80 мянга, 80-89 настай ахмадуудад 100 мянга, 90 ба түүнээс дээш настай ахмадуудад 200 мянган төгрөгийг жилд хоёр удаа олгох юм. Эхний ээлжинд “Насны хишиг”-ийг жилд хоёр удаа, цаашид эдийн засгийн нөхцөл байдал сэргэвэл улирал бүр олгохоор төлөвлөөд буй. Энэ талаар эрх баригчид ахмадууд “Насны хишиг”-ээ гоё мөн, сайхан агуулгатай хэмээн “амаа олохгүй” магтаж байгаа хэмээн тайлбарлаж байгаа. Мэдээж сөрөг хүчин эсрэг зүйл ярьж байгаа. Тэгвэл энэхүү асуудлыг гол баатрууд буюу ахмадууд ёстой нөгөө “оргүйд орвол охинтой нь дээр” гэхчилэнгээр хүлээн авч байгаа нь нууц биш. Юутай ч Засгийн газар ахмадуудаа хоосон үлдээсэнгүй. Амлалтандаа хүрч бага ч болов мөнгө өгөх гэж байгаа нь нэг талдаа авууштай. Нөгөө талдаа ёстой л бага хэмжээний мөнгөөр “нүглийн нүдийг гурилаар хуурсан” башир арга хэрэглэж байна уу да гэлтэй байна.

Энд хамгийн гол асуудал нь монголчууд хэд насалдаг вэ гэсэн судалгаа анхаарал татаж байгаа юм. Үндэсний статистикийн хорооны 2013 оны судалгаагаар монгол хүний дундаж наслалт 69.5 гэж гарсан байгаа юм. Хүйсээр нь салгавал эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрчүүдийнхээс арван насаар буюу 75 байдаг аж.Тэгвэл Ахмад настны тухай хуулийн төсөл, Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн аль нь илүү амьдралд нийцтэй вэ гэсэн дүгнэлтийг танд үлдээе.

# ДЭЛХИЙ



## Н.САРКОЗИЙН УЛИРАН СОНГОГДОХ МӨРӨӨДӨЛ ТАЛААР БОЛОВ

Б.ДАВАА

Францын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль ирэх жил болно. Гэсэн ч, аль хэдийнэ нэр дэвшигчид нь тодорч, нам доторх анхан шатны сонгаанууд тус улсад өрнөж эхэлсэн байна. Ирэх жилийн сонгуульд нэр дэвшихээ мэдэгдээд байсан эрхмүүдээс олны анхаарлыг хамгийн их татсан нь яах аргагүй экс Ерөнхийлөгч Николас Саркози байсан.

Догшин хэрцгий хуучинсаг үзэлтэй гэдгээрээ танигддаг Саркози өмнө нь тус улсыг таван жилийн хугацаанд тэргүүлж байсан ч, дэмжигчдийнх нь хувь огцом унасны улмаас улиран сонгогдож чадалгүй суудлаасаа унасан. Гэвч террорист халдлага удаа дараа болсонтой холбоотойгоор нэр хүнд нь унаж буй Франсуа Олландыг залгамжлахаар дахин Ерөнхийлөгчид хүч үзэхээр шийдсэнээ өнгөрөгч наймдугаар сард зарлаж, намын даргын суудлаасаа хүртэл буусан юм. Тэгвэл "Ардын хөдөлгөөний төлөөх холбоо" нам доторх урьдчилсан шатны сонгаанд Н.Саркози бүдэрчээ.

Урьдчилсан шатны сонгаанд долоон эрхэм өрсөлдсөн байх бөгөөд Н.Саркозигийн дэглэмийн үед Ерөнхий сайдаар ажиллаж байсан Франсуа Фи624 тэргүүлсэн бол экс Ерөнхий сайд Алайн Жуппе хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. Санал тооллогын ажиллагаа бараг дуусч байхад Ф.Фи624 44 хувийн дэмжлэг авсан байсан бол А.Жуппе 28, Н.Саркози 21 хувийн дэмжлэг хүлээжээ. "Өөрийн итгэл үнэмшлээ хамгаалахын төлөө өрсөлдсөн ч, олонхийн дэмжлэгийг авч чадсангүй" хэмээн дэмжигчдийнхээ өмнө мэдэгдэж, ялагдлаа хүлээн зөвшөөрсөн байна. Тус намын шийдвэрлэх шатны сонгаа энэ сарын 27-нд явагдах бөгөөд Франсуа Фи624 ялах магадлал өндөр байгааг ажиглагчид онцолж байгаа юм. Ямартай ч, энэхүү сонгаанд ялалт байгуулсан эрхэм ирэх жилийн тавдугаар сард болох Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж, хэт барууныг баримтлагч улс төрийн хүчин "Үндэсний фронт" намын дарга Марине Ле Пентэй өрсөлдөх бөгөөд тэдний хэн ялсан нь Францын дараагийн төрийн тэргүүн болох билээ. Үндэсний Фронт намын Ле Пений хувьд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хамгийн хүчтэй өрсөлдөгчид тооцогдож байгаа. Учир нь Үндэсний Фронт нам нь өнгөрсөн жилийн орон нутгийн сонгуульд илт давуу санал авч байсан, ард иргэдийн дунд нэр хүнд нь хамгийн өндөр байгаа нам юм.

## Барак Обама, Си Зиньпин нар ангын үсэн алчуур зүүжээ




Перугийн нийслэл Лима хотод Ази, номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын чуулга уулзалт зохион байгуулагдаж, өнгөрөгч ням гарагт хаалтаа хийв. Бүс нутгийн улс орнуудын өндөр дээд албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн энэхүү дээд түвшний уулзалтын хамгийн анхаарал татсан нэгэн агшин нь дурсгалын зураг татуулах хэсэг байлаа. Өмнө нь БНХАУ-ын Бээжин хотноо АПЕК-ын уулзалт зохион байгуулагдах үед Си Зиньпин ирсэн зочиддоо хятад үндэсний хантааз өмсүүлэн дурсгалын зураг татуулж байсан бол энэ удаагийн уулзалтаар Перугийн албаныхан уулархаг бүс нутагт амьдардаг "Викунья" гэх амьтны дээд зэрэглэлийн нарийн ширхэг бүхий үсээр хийсэн алчуурыг зочиддоо бэлэглэн зүүлгэж, дурсгалын зураг татуулсан байна. 2008 онд тус улсад мөн АПЕК-ын уулзалт зохион байгуулагдахад зочиддоо нөмрөг өмсүүлж, нэг хэсэгтээ л инээдэм наргианы гол сэдэв болж байсан удаатай. Тиймдээ ч энэ удаад өмнөх алдаагаа засахын тулд дурсгалын зурагт тун ч их ач холбогдол өгсөн тухай зарим эх сурвалж онцолж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама, БНХАУ-ын дарга Си Зиньпин, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ тэргүүтэй дэлхийн улс гүрний тэргүүнүүд буддын шашны лам лугаа адил ангын үсээр урласан цайны өнгөтэй алчуурыг мөрөн дээрээ тохон зургаа татуулсан аж. Андын нуруунд амьдардаг викунья гэх амьтны үс нь дэлхийн хамгийн ховор байгалийн утасны нэг бөгөөд маш тансаг зэрэглэлийн эдлэлд тооцогддог байна. Перугийн загварын салбарынхны хэлж буйгаар төрийн тэргүүнүүдийн зүүсэн нэг алчуур гэхэд 1500-3000 ам.долларын үнэд хүрдэг гэнэ. Дашрамд дурьдахад, викунья нь Перугийн бэлгэдэл ажээ.

## Ангела Меркель дөрөв дэх удаагаа канцлерт нэр дэвшихээ зарлалаа

Европын гол улс гэгдэж байгаа Германы хүчтэй удирдагч Ангела Меркель канцлерын албан тушаалд дөрөв дэх удаагаа нэрээ дэвшүүлэн өрсөлдөнө гэдгээ албан ёсоор мэдэгдлээ. Христийн Ардчилсан намын ээлжит хурлын үеэр Ангела Меркель энэ шийдвэрээ албан ёсоор танилцуулсан байна. Тэрбээр 2005 онд Германы анхны эмэгтэй удирдагчаар сонгогдсоноосоо хойш улс эх орондоо төдийгүй дэлхий дахины өмнө тулгарсан олон сорилтуудыг шийдвэрлэхэд өөрийн байр суурь, хүчтэй дуу хоолойг илэрхийлж ирсэн улстөрч юм. Энэ удаад дөрөв дэх удаагаа улиран сонгогдох хүсэлтэй байгаа цаад шалтгаан нь олон улсын тавцанд Германаас хамааралтай олон асуудал хүлээгдэж байгаатай холбоотой гэж тэрбээр тайлбарласан байна. Тодруулбал, Европ дахь цагаач, дүрвэгчийн хямрал, эдийн засгийг сэргээх тухай асуудал, АНУ-ын шинэ засаг захиргаатай баримтлах Европын бодлого зэрэгт Германы удирдагчийн байр суурь онцгой үүрэгтэй учир Меркелиэс өөр үүнийг хийж чадах хүн байхгүй гэх яриа ч гарсан байна. Канцлер Ангела Меркелийн баримталж байгаа нээлттэй хаалганы бодлогын хүрээнд цагаач, дүрвэгчдийн урсгалыг ихээр хүлээн авсан нь Меркелийн нэр хүнд ард иргэдийн дунд унах гол шалтгаан болсон гэж судлаачид үзэж байгаа. Гэвч "Сандэй" сонины судалгаагаар дийлэнх олонх Меркелийг дэмжсэн хэвээр байгаа гэж гарсан байна. Түүнийг тэргүүлдэг Христийн Ардчилсан нам дотор түүнтэй өрсөлдөх хүчтэй улстөрч байхгүй. Харин лалын шашинтныг эсэргүүцэгч Германы Альтернатив нам ирэх оны сонгуулиар Бундестагт олонхийн суудал авах магадлал өндөр байгаа ч канцлерт өрсөлдөх хүчтэй улстөрч нам дотор нь байхгүй гэж улс төр судлаачид үзэж байна.

## БНХАУ зэвсэгт хүчнээ өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүллээ

Мьянмарын зэвсэгт бүлэглэлүүд тус улсын БНХАУ-тай залгаа хил дээр байрлах цагдаа болон цэргийн шалган нэвтрүүлэх цэгүүд рүү халдсан хэрэг гарсны дараа БНХАУ зэвсэгт хүчнээ өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлжээ. Эдгээр хяналтын цэг нь мөргөлдөөнөөс дайжин дүрвэсэн олон хүний хувьд орогнох газар болдог юм.

Мьянмарын зүүн өмнөд нутгийн Шан мужийн Мусе болон Куткай хот дахь цэргийн шалган нэвтрүүлэх цэг рүү зэвсэглэсэн гурван бүлэглэл нэгэн зэрэг халдсан тухай Хятадын "Синьхуа" агентлаг ням гарагт мэдээлсэн байна. Халдлагын улмаас цэргүүд болон энгийн иргэд амиа алдсан гэж мэдээлэлд дурьджээ. БНХАУ-ын зэвсэгт хүчин өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн бөгөөд хилийн дагуу амьдарч буй хятад иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна гэж тус улсын аюулаас хамгаалах хүчин мэдэгдлээ.

Мьянмар дахь БНХАУ-ын консулын газар хилийн бүсэд хурцадмал байдлыг намжаахын тулд энхийн гэрээ байгуулахыг дэмжсэн байна. Мөргөлдөөнөөс дайжсан Мьянмарын иргэдийг Хятадын Засгийн газар орогнох байраар хангаж байна гэж мэдэгдэлд дурджээ. Мьянмарын Шан мужид засгийн газрын цэргүүд болон зэвсэгт бүлэглэлүүдийн хооронд олон жилийн турш үргэлжилж байгаа мөргөлдөөний улмаас энгийн иргэд орох оронгүй болж байна. Энэ мөргөлдөөн Хятадын муж руу түрэн орж, хэд хэдэн хятад иргэний аминд хүрсний дараа Хятадын эрх баригчид хариу арга хэмжээ авч эхэлжээ.

## Букингемын ордныг засварлана

Их Британийн нийслэл Лондон хотод байрлах Букингемын ордны барилга хэт хуучирч, усны хоолойноос ус гоожиж, гал гарч ч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүссэний улмаас засвар шинэчлэлтийн ажлыг хийж хэрэгжүүлэхээр болжээ.

Засварын ажилд тус улсын Засгийн газраас нийтдээ 369 сая фунт стирленгийг төсөвлөөд байгаа бөгөөд энэ үеэр хатан хаан хоёрдугаар Элизабет ч гэсэн өөр өрөө рүү нүүхээс өөр аргагүйд хүрчээ. XVIII зууны үед баригдсан 775 өрөөтэй Букингемын ордонд дэлхийн хоёрдугаар дайны дараа үе буюу Германы бөмбөгдөлтөөс хойш томоохон хэмжээний засвар огт хийгээгүй ажээ. Засварын ажил ирэх жилүүдэд үргэлжлэх бөгөөд 2027 он гэхэд бүрэн дуусах гэнэ. Дашрамд дурьдахад, Букингемын ордны дээвэр дээр нарны эрчим хүчийг хуримтлуулах тавцанг байрлуулахаас гадна жуулчдад үйлчлэх хэсгийг мөн бий болгох юм байна.



# ШУУРХАЙ МЭДЭЭ

Аймгаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

## Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргаар Ч.Энхмэнд томилогдлоо

Эрдэнэ сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын Нам олонхи болж, тус сумын ИТХ-ын хуралдаанаар Эрдэнэ сумын Засаг даргаар Ч.Энхмэндийг 100 хувийн саналаар дэмжиж, аймгийн Засаг даргад уламжилжээ. Үүний дагуу өчигдөр аймгийн Засаг даргын Б/97 тоот захирамж гарч Эрдэнэ сумын Засаг даргаар Ч.Энхмэнд албан ёсоор томилогдлоо. Мөн аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин орон нутгаас баримталж буй бодлого шийдвэр, зохион байгуулах үйл ажиллагааны талаар Эрдэнэ сумын Засаг даргатай харилцан санал солилцож, цаашдын ажил үйлсэд нь амжилт хүслээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

## ЗУАШ гандболын тэмцээний шилдгүүд тодорлоо

Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 байгууллагын 160 гаруй тамирчин гурван өдрийн турш хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шилдгүүдээ тодруулллаа. Эмэгтэй багийн тэргүүн байрт Т.Ууганбаяр дасгалжуулагчтай, Ц.Нарангарав ахлагчтай Сэлэнгэ аймгийн Баянгол баг, II дугаар байрт Б.Бадрангуй дасгалжуулагчтай, С.Ариунаа ахлагчтай Их Монголын хүч баг, III дугаар байрт Г.Амарсанаа дасгалжуулагчтай Б.Мөнгөнчимэг ахлагчтай Мон-Алтиус биеийн тамирын дээд сургуулийн баг шалгарчээ. Харин эрэгтэйчүүдийн багийн тэргүүн байрт Л.Амартүвшин дасгалжуулагчтай, И.Амарбаясгалан ахлагчтай “Аварга” БТДС-ийн баг, Г.Амарсанаа дасгалжуулагчтай, Б.Нямболд ахлагчтай “Мон-Алтиус” биеийн тамирын дээд сургуулийн баг, Л.Загдсүрэн дасгалжуулагчтай, Б.Баясгалан ахлагчтай ХААИС-ийн багууд удаалаа. Тус тэмцээний шилдэг хаалгачаар Сэлэнгэ аймгийн Баянгол багийн Б.Лхагвадулам, “Аварга” БТДС-ийн Л.Лхагвазориг, шилдэг довтлогчоор Их Монголын хүч багийн С.Ариунаа, “Аварга” БТДС-ийн Б.Отгонбаатар нар шалгарсан байна. Энэ жилийн залуучуудын улсын аварга шалгаруулах гандболын тэмцээнийг Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Монголын Гандболын холбоотой хамтран зохион байгуулсан юм. Тэмцээний хаалтын ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Н.Нарантуяа, МГХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энэбиш, аймгийн БТСГ-ын дарга Б.Баттулга нар оролцлоо.

ТӨВ АЙМАГ

## Д.Нацагдоржийн ойд зориулж эрдэмтэд чууллаа

Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал боллоо. Эрдэм шинжилгээний хуралд БСШУС-ын дэд сайд Ё.Отгонбаяр, ШУА-ын ерөнхийлөгч Т.Рэгдэл, аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, аймгийн нутгийн зөвлөлийн дарга Д.Дондог нар оролцсон байна. Уг хуралд нийт 25 илтгэл тавигджээ. Тус эрдэм шинжилгээний хурлыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич Л.Болд удирдан явуулсан бөгөөд нарийн бичгийн даргаар ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Хэл бичгийн ухааны доктор Б.Мөнхбаяр нар ажиллажээ.

ХЭНТИЙ АЙМАГ

## Долоон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйд тусалжээ

Хэрлэн сумын V дугаар багийн 0-18 насны долоон хүүхэдтэйгээ таван ханатай гэрт амьдардаг Ц.Ганчимэг эмэгтэйд туслаж, байшинг нь барьж дуусгах сайн үйлсийн ажлыг амжилттай хэрэгжүүлж дууслаа. Энэ оны хавар Ц.Ганчимэгийг Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас хэрэгжүүлдэг “Шинэ байшин” төсөлд хамруулсан боловч хүн хүч муутайн улмаас байшингаа битүүлж чадалгүй өвөлтэй золгож, төслийн хугацаа ч дууссан байна. Тиймээс Дэлхийн зөнгийн хамт олон байшинг нь барьж дуусгах арга хайж, багийн ахлагч Б.Мөнхжаргал нь “Хэнтийн мэдээ” сонины редакцид анх хандсан юм. Ингээд тус сонины сэтгүүлч өрх толгойлсон эмэгтэйн тухай сурвалжлага бэлтгэн сонины дугаар, цахим хуудсандаа нийтэлснээр сайхан сэтгэлт хүмүүсийн хандив цугларч эхэлжээ. Хандивын дансанд Г.Чинбаяр захиралтай Хэнтий аймгийн Барилгын “СИ ЭЙЧ БИ ЖИ КОНСТРАКШН” ХХК 200, Д.Одонтунгалаг эрхлэгчтэй “Хэнтийн мэдээ” сонины редакц 100, Э.Хишигтогтохын гэр бүл 50000, Б.Даваажавын гэр бүл 50, Т.Наранбаатарын гэр бүл 40, н.Ариунжаргал 20 мянган гэх зэргээр бэлэн 500 орчим мянган төгрөг, мөн С.Эрдэнэжаргал даргатай аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нэг сая 200 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус үзүүлсэн ажээ. Хандивын мөнгөөр 5*8 хэмжээтэй байшинг битүүлэх, пийшин барих, дотор засал хийх зэрэг ажлуудыг Ц.Ганчимэгийн хоёр том хүүтэй нь хамтран н.Батсүх хэмээх залуу хөнгөлөлттэй үнээр хийж гүйцэтгэжээ.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс сургалт зохион байгуулав

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тухай ойлголт”, “Төлөвлөлт, түүний ач холбогдол”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичиг, заавар журам”, “Тайлан ирүүлэхэд анхаарах асуудлууд, жишээ” зэрэг сэдэвт хичээл орсон ажээ. Сургалтад 24 байгууллагын 27 албан хаагч хамрагдсан бөгөөд тус сургалтаар тайлангийн талаар нэгдсэн ойлголттой болж, цаашдын хамтын ажиллагаагаа тодорхойллоо.

# ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ 1.7 ХУВИАР ӨСЧЭЭ

Н.БАТЗАЯА

*Улаанбаатар хотын цагдаагийн газрын дарга, хурандаа Ж.Эрдэнэболдоос зарим зүйлийг тодрууллаа.*

**-Он гарсаар нийслэлийн хэмжээнд хэчнээн гэмт хэрэг бүртгэгдсэн байна вэ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Улаанбаатар хотын хэмжээнд тусгай зориулалтын 102 дугаарын утсанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хоногт дунджаар 1500-2000 гэмт хэрэг, зөрчлийн тухай дуудлага мэдээлэл ирж байна. Өөрөөр хэлбэл, дүүрэг дэх нэг цагдаагийн хэлтэс хоногт 100-130 хэрэг, зөрчлийн тухай дуудлага ирдэг. Нийт ирсэн дуудлагын 60-70 нь гэмт хэргийн, 1000-1100 нь зөрчлийн, 450-500 нь согтуугийн, 400-450 нь зам тээврийн ослын дуудлага мэдээлэл байна. Улсын хэмжээнд энэ оны эхний 10 сарын байдлаар 406137 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн. Үүний 15257 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 61 хувийг эзэлж байгаа юм. Энэ нь өмнө оны мөн үеийнхтэй харьцуулахад 252 хэргээр буюу 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**-Бүртгэгдсэн гэмт хэргийн ихэнх хувийг ямар хэрэг эзэлж байна вэ?**

-Нийслэлд бүртгэгдсэн нийт 15257 гэмт хэргийн ихэнх буюу 34.4 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа. Тиймээс цагдаагийн газраас хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Мөн хулгайн эд зүйлсийг зарж, борлуулах зах зээлийг хаах зорилгоор барьцааны мэдээллийн цахим бүртгэл, хяналтын системийг бий болгохоор ажиллаж байна. Мөн гэмт хэрэг захиргааны зөрчлийн мэдээллийг бүрэн хэмжээгээр газрын зурагт тэмдэглэж, түүнд тулгуурлан гэмт хэргийн мэдээллийг судлан дүн шинжилгээ хийх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хүч, техник хэрэгслийг оновчтой хуваарилах зэрэгт ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор бусад орны хууль сахиулах байгууллагуудад хэрэглэгддэг ArcGIS газар зүйн мэдээллийн системд суурилсан “Гэмт хэргийн цахим зураглал”-ыг боловсруулан туршиж ажиллалаа.

> ...гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй, эмзэг цэгийн судалгааг гаргаж, шинээр хяналтын камерыг байршуулан нэгдсэн төвтэй холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. Түүнчлэн бид “Эргүүл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна...

**-“Гэмт хэргийн цахим зураглал”-ыг боловсруулан туршиж байна гэлээ. Энэ талаар тайлбарлахгүй юу?**

-“Гэмт хэргийн цахим зураглал систем”-ийг нэвтрүүлснээр гэмт хэрэг болон хэв журмын нөхцөл байдлыг дүгнэх, гэмт хэрэгт өртөөд буй эмзэг цэгүүдийг тодорхойлон гэмт хэргийг үйлдсэний дараа олж илрүүлэх бус үйлдэгдэхээс өмнө шалтгаалан нөхцөлийг арилгах, хариу арга хэмжээ авч гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэхдээ нийслэлийн хэмжээнд нэвтрүүлсэн “Гэмт хэргийн цахим зураглалын систем”-ийг хөгжүүлэн боловсронгуй болгож эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нэгдсэн төв бий болгон үр дүнг тооцохоор төлөвлөсөн.

**-Цаашид гэмт хэргийн гаралтыг бууруулах тал дээр ямар арга хэмжээ авч ажиллах вэ?**

-Нийслэлийн гудамж, зам, талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Камерын хяналтын удирдлагын нэгдсэн төв бүхий “Теле хяналтын камер” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд суурилагдан ашиглагдаж байгаа 1600 ширхэг телехяналтын камерыг удирдлагын нэгдсэн төвтэй холбох ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй, эмзэг цэгийн судалгааг гаргаж, шинээр хяналтын камерыг байршуулан нэгдсэн төвтэй холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. Түүнчлэн бид “Эргүүл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Энэ хүрээнд хэв журмын урамшилт эргүүлийг ажиллуулах 4000 чиглэлийн судалгааг гаргах ажлыг эхлүүлсэн.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ЗУНЫ ДУГУЙТАЙ МАШИНЫГ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦУУЛАХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЛАА

Ойрын өдрүүдэд үргэлжлэн орсон цасны улмаас нийслэлийн гудамж талбай, авто замуудад хальтиргаа гулгаа ихээр үүсээд байна. Улмаар явганаас бэртэж гэмтсэн хүмүүсийн тоо эрс ихэссэнээс гадна зам дээр мөргөлдсөн авто ослын дуудлага энгийн өдрүүдээс даруй хоёр дахин өсчээ. Тухайлбал, энэ сарын 19, 20-ний өдрүүдэд буюу өнгөрөгч амралтын хоёр өдөрт Замын цагдаагийн албаны шуурхай удирдлагын төвд 853 дуудлага мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 730 дуудлага бүртгэгджээ. Дээрх ослын улмаас нэг хүний амь нас хохирч, 14 хүн хүнд хөнгөн бэртэл авч, сургуулийн насны таван хүүхэд гэмтжээ. Ийнхүү нийт нутгаар цас орж хальтиргаа гулгаа үүссэнтэй холбогдуулан Замын цагдаагийн албанаас, замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарыг цаг агаарын нөхцөл байдал, тээж яваа ачаа, замын зорчих хэсэг гадаргууны байдалд тээврийн хэрэгслийн хурдаа зөв тохируулан анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцохыг сануулж байна.

## 18 жил дарагдсан С.Зоригийн хэргийг М.Алдар шүүхээр болов

Ардчиллын алтан хараацай С.Зоригийн амийг одоогоос 18 жилийн өмнө онц хэрцгийгээр хөнөөсөн хэрэг гарсан билээ. Тэгвэл эл хэрэгтэй холбогдуулан талийгаачийн эхнэр Б.Булган, мөн Орхон аймгийн харьяат иргэн Т.Чимгээ, Б.Содномдаржаа, Ц.Амгаланбаатар нарыг саатуулан шалгаж эхэлсэн. Түүгээр ч барахгүй Хотын захирагч асан Э.Бат-Үүлийг ч уг хэрэгт холбогдуулан шалгасан удаатай. Тэгвэл эл хэрэгт холбогдуулан прокуророос яллах дүгнэлт үйлдэж, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлжээ. Үүнээс гадна уг хэрэгт оролцох шүүгчдийг ч томилсон байна. Тодруулбал, нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Ерөнхий шүүгч М.Алдарт 18 жилийн өмнө гарсан эл хэргийг хариуцуулжээ. Мөн энэ хэрэг нь маш нууцын зэрэглэлд багтаж байгаа хэмээн Улсын ерөнхий прокурорын газраас тодотгож, нэмэлт мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа аж.

## Эрэн сурвалжилж байсан этгээдийг барьсан гэв

Цагдаагийн байгууллагад энэ сарын 17-ны 15:00 цагийн үед Баянгол дүүргийн дөрөвдүгээр хороо, Улаанбаатар төмөр замын ногоон зооринд “зодоон болоод байна” гэх дуудлага ирсэний дагуу шалгахад иргэн М нь мэсний шархтай байсан бөгөөд гэмт этгээд хэргийн газрыг орхиж зугтаасан хэрэг гарсан билээ. Уг хэргийг үйлдсэн байж болзошгүй этгээдийг эрэн сурвалжилж өнгөрсөн бямба гарагт баривчилжээ. Түүнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96.2.5 зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн Төмөр зам дахь цагдаагийн хэлтэст шалгаж байна. Уг гэмт хэргийг 1966 онд төрсөн эрхэлсэн тодорхой ажилгүй Ш, 1986 онд төрсөн Б нар бүлэглэн үйлдсэн. Эхний мөрдөн байцаалтаар гэмт хэргийг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд ямар нэгэн этгээдийн захиалгаар хийгээгүй хувийн өс хонзогийн сэдлээр М гэгчид халдсан гэж мэдүүлжээ. Мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжлэж байна.

PHOTO NEWS





*Нийслэлийн удирдлагууд цаг агаарын нөхцөл байдал, халтьргаа гулгаа их байгаатай холбогдуулж өчигдөр өглөө Шуурхай зөвлөгөөнөө хийлээ. Энэ үеэр цас цэвэрлэгээний асуудлыг хэрхэн хурдан шийдэх талаар ярилцаж, нийслэлийн Засаг дарга С.Батболд нийслэлээс гадагш гарах зам давааны цас мөсийг арилгах ажилд хүч нэмэгдүүлэх, холбогдох байгууллагуудтай нь ярилцсаны үндсэн дээр цэргийн алба хаагчид болон оюутан, ахлах ангийн сурагчдыг энэ долоо хоногт гудамж талбайн цасыг цэвэрлэх ажилд туслуулахыг үүрэгдсэн байна.*

NO STRESS

Оддын ЦАГ

# Рене Зеллвегер: Хуучны танил газартаа эргэн ирж буй мэт мэдрэмж төрсөн



Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

"Брижет Жонсын өдрийн тэмдэглэл" киноныхоо дүрээр манай кино сонирхогчдод аль хэдийнэ танигдсан эрхэм бол жүжигчин Рене Зеллвегер. Энэ онд тус киноны гурав дахь цуврал нээлтээ хийсэн бөгөөд гол дүрд мэргэжлийн ажлаасаа нэлээд хугацаанд хөндийрсөн жүжигчин бүсгүй тоглож, кино урлагтаа эргэн ирсэн билээ. Уг кинонд Брижет Жонс бүсгүй жирэмсэн болсноор инээд хүргэм адал явдал өрнөх юм. Ингээд жүжигчин бүсгүйн шинэхэн уран бүтээлийнхээ талаар дэлгэсэн ярилцлагыг орчуулан хүргэж байна.

**-"Брижет Жонсын өдрийн тэмдэглэл" кино гуравхан цувралтай. Гэсэн хэдий ч, яагаад ийм урт хугацааг зарцуулан бүтээгдэж байгаа юм бэ?**

-Цаг хугацаа, мэдрэмж зарцуулан бүтээж буй нь харин ч сайн хэрэг биш гэж үү. Брижет Жонсын өөрчлөлт, өсөлт хөгжил, басхүү мэдрэмж нь кинонд шингэн гарах учраас тэр л дээ. Яг зөв цагтаа цувралын шинэ анги гарсан гэж бодож байна. Эмэгтэй хүн гэдэг амьдралдаа юу эсийг туулах билээ. Магадгүй хүүхэдтэй болох нь хамгийн сүүлчийн боломж байх. Бас жил ирэх тусам өмнөхөөсөө ч илүү том асуудалтай нүүр тулгардаг. /инээв/

**-Удаан хугацааны дараа Брижет Жонсын дүрд тоглох ямар байв. Та одоо телевизийн продюсерээр ажилладаг ч, өмнөх шигээ л тус дүрийг бүтээсэн байна шүү дээ?**

-Тийм шүү. Яг л хаа нэгтээ орших хуучны танил газартаа эргэн ирж буй мэт сонин мэдрэмж төрсөн. Бэлтгэлийн явцад ч гэсэн ижилхэн байж билээ. Брижет Жонс энэ хүртэл хэрхэн өсч хөгжсөнийг дахин сөхөж буй мэт. Тэр бүсгүй яаж өөрчлөгдсөн бол, аль эсвэл огт өөрчлөгдөөгүй болов уу гэх мэтээр. Би түүний бүтэлгүйтэл, болхи эв хавгүй байдлыг хоёуланг нь мэдэрдэг. Хэн нэгэн ямар нэг хэцүү зүйлийг хийхийг оролдож, улмаар бүтэлгүйтэж буй тэр агшныг харах үнэхээр инээдтэй шүү дээ. Түүний өөрийнхөө талаар ярьж буй хэсэг хамгийн хөгжилтэй нь байсан.

**-Дүрийнхээ талаар яриач?**

-Энэ дүрд намайг санамсаргүй сонгосон гэж бодохгүй байна. Брижет Жонсын дүрийг бүтээснээр амьдралд минь маш их зүйл өөрчлөгдсөн. Тэр бол надад өгсөн гайхалтай бэлэг байлаа. Бас нөхөрлөл хийгээд туршлагыг хамтад нь өгсөн. Маш олон хүнд хайрлагдсан дүрийн амьдралаар амьдрах миний хувьд нэр төрийн хэрэг гэж боддог.

**-Рене та бараг зургаан жил орчим хугацаанд уран бүтээлээсээ хөндийрсөн. Энэ хугацаанд юу хийж байв даа?**

-Олон жилийн турш хамтран ном бичиж байгаа хамтрагчтайгаа телевизийн нэвтрүүлэг хийгээд тун завгүй байлаа. Туршилтын хувилбараа дуусгачихсан. Сургуульд сурч, кино уран бүтээлийн судалгаа ч хийсэн. Жүжигчний ажил гэдэг гайхалтай, хөгжилтэй хэрнээ их завгүй байдаг учраас амьдралын нарийн зүйлсээ амжуулж чадахгүй байх тохиолдол бий. Тиймээс их сургуульд сурч байхдаа өөртөө амласан амлалтаа биелүүлэхийн тулд зориуд ийм шийдвэр гаргасан юм. Бусад хүмүүсийн адил өсч хөгжихийг хүссэн учраас тэр. Гэхдээ эцэст нь хийсэн нэвтрүүлгээ худалдаж чадаагүй ч гэсэн бизнесийг огт өөр өнцгөөс хардаг болсон. Сайн туршлага хуримтлуулсан гэж хэлж болно.

**-Тийм байх нь ээ. Эдүгээ ярианы гол сэдэв болж буй эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийн талаар та ямар бодолтой байдаг вэ. Эмэгтэйчүүд өмнөхөөсөө ч илүү хүчтэй болсон гэдэгтэй санал нийлдэг үү?**

-Маш олон зүйл өөрчлөгдсөн мэт санагддаг. Би эмэгтэйчүүд ч гэсэн өөрийн явах ёстой замаа сонгож, чухал албан тушаал хаших эрхтэй гэж бодож өсч хүмүүжсэн хүн л дээ. Гэхдээ тухайн нийгмээсээ шалтгаалаад эмэгтэйчүүдийг хүлээж авах хандлага нь харилцан адилгүй байх нь бий. Бид Хиллари Клинтон ч юмуу, эсвэл өмнөх эрин үеийн эмэгтэйчүүдийн эдүгээг хүртэл хийж хэрэгжүүлсэн бүхэнд хангалттай талархаж байгаагүй юм шиг санагддаг. Яагаад гэвэл өнөө цагт тэдэн шиг хүнд хэцүү бүхнийг туулж, тэмцэх шаардлагагүй учраас тэр. Өнөөгийн нийгэм дэх өөрчлөлттэй тэдний хичээл зүтгэл салшгүй холбоотой шүү дээ. Өнөөдөр эмэгтэйчүүд хэнээс ч эмээж, эргэлзэхгүйгээр хэлэх гэсэн үгээ хэлж, хийх гэсэн зүйлээ хийдэг болсон. Энэ утгаараа тэдэнд баярлах хэрэгтэй.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -18
Шөнө -27

Нөгөөдөр
Өдөр -15
Шөнө -25

Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:** Эд эдлэл идээ ундаа олдоно

**Наран ургах, шингэх:** 08.10-17.15

**Өдрийн өнгө:** Дашням, Балжиннямтай



*Аргын тооллын 11 сарын 21, Сумъяа гараг. Билгийн тооллын 23, Их морь одтой, улаагчин хонь өдөр. Өдрийн наран 8 цаг 10 минутад мандан, 17 цаг 15 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын сууръ тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.*

Бидэнд тохиолдсон ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Orgil Toppy

Номын сангийн буудлаас Зайсан чиглэлийн автобусанд суух гэтэл багтсангүй. Автобус Хөдөө аж ахуйн сургуулийн оюутнуудаар дүүрчихсэн. Тэгтэл нэг приустай ах Зайсан 1000-аар гээд зогслоо. Ажил руугаа яарсан, даарсан давхцаад гялс суув. Дөрвөн хүн суугаад хөдөлтөл жолооч нь би та нарыг үнэгүй хүргээд өгье. Хэдэн хүмүүст ч болтугай буян болъё гэж бодсон юм. Сая Зайсан үнэгүй гээд хэлчихвэл оюутнууд машин эвдчих байх гэж айгаад гэдэг юм даа. Хөгжилтэй, буянтай ах байна билээ. Хэ хэ хэ.

ДУУЛГАХ СОНИН

## Мисс А.Баярцэцэгт Мандухай хатны гоёлыг дурсгав



"World Miss" буюу дэлхийн гоо үзэсгэлэнгийн олимп гэгддэг нэр хүндтэй тэмцээнд манай улс 2005 оноос авьяас билэг, гоо үзэсгэлэн, мэдлэг боловсролоороо бусад охид бүсгүйчүүдээ манлайлж чадсан үндэсний шилдэг оролцогчоо тус тэмцээнд амжилттай оролцуулсаар ирсэн. Тэгвэл "World Miss" буюу "Дэлхийн мисс-2016" тэмцээн энэ жил АНУ-ын Вашингтон хотноо ирэх сарын 29-нөөс арванхоёрдугаар сарын 18-нд болох гэж байна. Дэлхийн гоо үзэсгэлэнгийн олимпод эх орноо төлөөлөн "Торго модель" агентлагийн загвар өмсөгч, мисс А.Баярцэцэг оролцохоор болсон билээ. Дэлхийн миссийн тэмцээнд Монгол Улсаа төлөөлж, хэдхэн хоногийн дараа хүлгийн жолоо залах гэж буй мисс бүсгүйг үдэн гаргах ёслолын үйл ажиллагаа саяхан болж, алдар хүндтэй олон зочин уригджээ. Энэ дундаас Төрийн шагналт, гавьяат жүжигчин Намсрайн Сувд дэлхийн гоо үзэсгэлэнгийн олимпод эх орноо төлөөлөх гэж буй үзэсгэлэнт бүсгүйд "Мандухай сэцэн хатан" кинонд тоглож байхдаа хэрэглэж байсан нэгэн гоёл чимэглэлээ бэлэглэсэн сурагтай.

## Чөлөөтийнхөн 14 медаль хүртлээ

ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотын Биеийн тамир, спортын Оросын домогт бөх Б.Будаевын нэрэмжит олон улсын залуучуудын XXIY дэх удаагийн тэмцээн болж өндөрлөлөө. 23 хүртэлх насны залуучуудын дунд 52, 57, 61, 65, 70, 74, 86, 97 кг-ын жингүүдэд ангиллаар болсон тус тэмцээнээс манай тамирчид дөрвөн алт, таван мөнгө, таван хүрэл медаль хүртжээ. Эхний өдөр дөрвөн жингийн барилдаан болж "Арслан" клубын бөх З.Занабазар 55 кг-ын жинд, Т.Тулга 60 кг-ын жинд, Б.Отгонбаяр 74 кг-ын жинд алтан медаль авсан байна. Мөн З.Сумьяабазар 74 кг-ын жинд, "Алдар" спорт хорооны бөх Г.Ханбүргэд 66 кг-ын жинд мөнгөн медаль хүртсэн аж. Түүнээс гадна, 74 кг-ын жинд Б.Бямбадорж, БТСДуС-ийн бөх Ц.Цогбадрах 55 кг-ын жинд хүрэл медаль хүртжээ. Тэгвэл тэмцээний хоёр дахь өдөр 97 кг-ын жинд "Аварга" ахлах сургуулийн бөх Б.Одсүрэн алт, Ч.Алтангэрэл, Г.Ганхуяг, М.Лхагвагэрэл нар мөнгөн медаль хүртсэн байна. Харин Н.Насанбуян 50, А.Мөнх-Эрдэнэ, 60, Ж.Бат-Оргил 125 кг-ын жинд тус бүр хүрэл медаль хүртсэн ажээ.





ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**

- IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ

-Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

**Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.**
**Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021**